



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/1016

Улаанбаатар хот

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, л, 29.2, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт түүхий нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай:


2.1. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ыг хэрэгжүүлж ажиллахыг "Таван толгой түлш" ХХК /М.Ганбаатар/-д;

2.2. Сайжруулсан шахмал түлш ачих, буулгах, тээвэрлэх, савлах, түгээх ажилд дэмжлэг үзүүлэхэд хот нийтийн аж ахуйн ажилтнууд болон бусад хүний нөөцийг бүрдүүлэх, машин, техник хэрэгсэл дайчлан зохион байгуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд, сайжруулсан шахмал түлш тээвэрлэж буй тээврийн хэрэгслийг батлагдсан маршрутын дагуу дугаарын хязгаарлалтгүйгээр саадгүй зорчуулах боломжоор хангаж ажиллахыг Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар /Д.Дашдорж/-т;

2.3. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2, 3 дугаар бүсийн айл өрхүүдийн сайжруулсан шахмал түлшний хуваарилалтыг жигд хүртээмжтэй хангах, хэрэглээнд хяналт тавих зорилгоор сайн картыг иргэдэд бүрэн хүргэх, мэдээллийн сан үүсгэж, цахим бүртгэл хөтлөх арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /М.Халиунбат/, Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/, Нийслэлийн Бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, дүүрэг, хорооны Засаг дарга нарт;

2.4. Сайжруулсан шахмал түлш түгээх цэгийн тоог нэмэгдүүлэх, байршил, цагийн хуваарьтай холбоотой мэдээллийг иргэдэд хамгийн ойр эх сурвалжаас хүртээмжтэй хүргэх ажлыг хэвлэл, мэдээлэл олон нийтийн байгууллагыг оролцуулан зохион байгуулахыг Нийслэлийн Инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /М.Халиунбат/, дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т;

111020904747



ЗАСГИЙН ГАЗРЫН 62 ДУГААР ТОГТООЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ӨНДӨРЖҮҮЛСЭН
БЭЛЭН БАЙДАЛД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1.	Сайн түлшний картыг нэвтрүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх	Карт ашиглах журмыг батлах	Инноваци, технологи хариуцсан орлогч	"ТТТ" ХХК, НМТГ	2019.10.05
		Мэдээллийн цахим сан үүсгэх			
		Картыг идэвхжүүлэх			
2.	Сайжруулсан түлш савлах, ачих, буулгах хүний нөөцийг бүрдүүлэх	Түлш савлах, ачих, буулгах	Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч	НХЭГ, Дүүргүүдийн Засаг дарга нар	2019.10.05
		Түлш тээвэрлэх			
3.	Сайжруулсан түлшийг бөөний болон жижиглэнгийн цэгүүдэд хүргэх тээврийн хэрэгслийг дугаарын хязгаарлалтгүй саадгүй зорчуулах	Түлш тээвэрлэх	Зам, тээврийн асуудал хариуцсан орлогч	ТЦА, НХТЗИГ	2019.10.05
4.	Сайжруулсан түлш ачих, буулгах хүний нөөцийг бүрдүүлэх, тээвэрлэх, савлах, түгээх ажилд дэмжлэг үзүүлэхэд хот нийтийн аж ахуйн ажилтнууд, машин, техник хэрэгсэл, холбогдох бусад нөөцийг дайчлан зохион байгуулах	Түлш тээвэрлэх, савлах, ачих, буулгахад хүний нөөц, техникийн дэмжлэг үзүүлэх	Улаанбаатар ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга	Дүүргүүдийн Засаг дарга нар	2019.10.05
		Борлуулалтын цэгийг нэмэгдүүлэх	"ТТТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал	Дүүргүүдийн Засаг дарга нар	2019.10.05
5.	Сайжруулсан түлшний борлуулалтын цэгүүдийг тоог нэмэгдүүлэх, тэдгээрийг түлшээр бүрэн хангах	Түлшээр бүрэн хангах	Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч	Дүүргүүдийн Засаг дарга нар	2019.10.05
		Борлуулалтын цэгийн	Инноваци, технологи	Дүүргүүдийн Засаг дарга нар	2019.10.05

2.5. Сайжруулсан шахмал түлшний үнийг үйлдвэрийн үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдалд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Д.Ядамдорж/, дүүрэг, хорооны Засаг дарга нарт;

2.6. Сайжруулсан шахмал түлшний чанар, стандартад тогтмол хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Агаарын бохирдолтой тэмцэх газар /Х.Галымбек/-т;

2.7. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Улаанбаатар хотод түүхий нүүрс нэвтрүүлэхгүй, хэрэглүүлэхгүй байх чиглэлээр хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Д.Ядамдорж/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т;


2.8. Гэрээ хийгдсэн тээврийн компаниудын машин техникийн бүрэн бүтэн байдал, тоо, хүчин чадлыг нарийвчлан тодорхойлох, хоногт 2500-5000 тонн түлшийг бөөний, дундын, жижиглэнгийн цэгүүдэд хүргэх үйл ажиллагааг нарийвчлан төлөвлөж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/-д;

2.9. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан захирамжаар өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 24 цаг тутамд гаргаж Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв /ОНӨААТҮГ/-д хүргүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагуудад, ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэж 7 хоног тутам Нийслэлийн Онцгой комисст танилцуулж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Х.Гантулга/-т;

3. Холбогдох зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Э.Содномжамц/, дүүргийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч /Ж.Батбаясгалан/, Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/ нарт тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

		Байршил, ажиллах цагийн талаар мэдээлэх	ажиллах хуваарийн тавих арга	Хариуцсан орлогч, Хот асуудал орлогч	Байгууллагын хариуцсан орлогч	дарга нар, НЭДТГ-ын ХМХХ, НҮНТ	
		Хяналт шаардлагатай хэмжээ авах	Түүхий нүүрс хэрэглэхийг зөвшөөрсөн хороодод тэвэрлэх зөвшөөрөл олгох	Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч		НМХГ, НЦГ	Тогтмол хийх
6.	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс хэрэглүүлэхгүй байх	Эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд түүхий нүүрс тэвэрлэх зөвшөөрөл олгох	Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга	Дуургуудийн Засаг дарга нар, НАБТГ, НМХГ, НЦГ	Дуургуудийн Засаг дарга нар, НАБТГ, НМХГ, НЦГ	Тогтмол хийх	
7.	Түлээний нөөц бүрдүүлэх	Түлээний нөөц бүрдүүлэх	Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч	НБОГ		Тогтмол хийх	2019.10.05
8.	Орон тооны бүс ажилтныг чиг үүргээр хангах, зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийг хянах, түлш савлах, ачих, буулгахад дэмжлэг үзүүлэх, хүний нөөц бүрдүүлэх	Хүний нөөц бүрдүүлэх	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга	НШШГА, НЦГ		Тогтмол хийх	2019.10.05
9.	Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажлын хэсэг байгуулах	Төлөвлөгөө гаргах	Инноваци, технологи хариуцсан орлогч	НЭДТГ-ын ХМХХ		Тогтмол хийх	2019.10.05